

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ СУДАЛГАА /ХЭНТИЙ АЙМГИЙН ЖИШЭЭН ДЭЭР/

О. Арсланбаатар
“Төрийн удирдлага” хөтөлбөрийн магистрант

Бизнесийн ахисан түвшний сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль

mr.aagy9811@gmail.com

Д. Одмаа
Доктор (Ph.D), дэд профессор

Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Шинжлэх ухаан технологийн их сургууль

odmaadanga@gmail.com

Хураангуй: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны өнөөгийн байдал, иргэдийн оролцоонд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор уг судалгааг хийсэн. Энэ хүрээнд иргэдийн оролцооны онол, үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн сангийн тухай хууль эрх зүйн орчин, Хэнтий аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт дэх иргэдийн оролцооны өнөөгийн байдал, холбогдох тайлан, мэдээлэл зэргийг судалж, шинжилгээ хийсэн. Судалгаа авахдаа анкетийн арга, бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга, баримт бичгийн шинжилгээний аргыг тус тус ашигласан. Судалгааны үр дүнд сум, багаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд иргэдийн оролцоо бага, түүнчлэн ОНХС-гийн талаар иргэдийн 63,2% нь мэднэ гэсэн боловч 53,7% нь өөрийн хорооны ОНХС-гийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй гэж хариулсан байна. Үүнд нөлөөлж буй гол хүчин зүйл нь мэдээлэл дутмаг байдал гэж үзсэн. Иймд ОНХС-гийн үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй оролцуулахын тулд тэдэнд чиглэсэн мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод, оновчтой хэлбэрээр хүргэх хэрэгтэй байна.

Түлхүүр үгс: Төрийн үйлчилгээ, орон нутаг, хөгжил, төлөвлөлт, санхүүжилт, шийдвэр

УДИРТГАЛ

Монгол улсын төрөөс ардчиллыг бэхжүүлж, төвлөрлийг сааруулах нь үр дүнтэй, хүртээмжтэй хөгжилд хүрэх гол шинэчлэл гэж үзэн энэ хүрээнд сайн засаглалын үндэс суурь болох шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төвлөрлийг сааруулж төрийн хариуцлагын тогтолцоог сайжруулахыг зорьж байна. Тухайлбал, иргэдийн оролцооны эрхийг баталгаажуулсан заалт бүхий Төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга

2011 онд батлагдаж 2012 оноос хэрэгжиж эхэлсэн байдаг. Орон нутгийн хөгжлийн сан (цаашид ОНХС гэх) нь орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг тухайн нутагт оршин суугаа иргэдээс гаргасан санал санаачилгын үндсэн дээр шийдвэрлэх, орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан хуваарилж буй хөрөнгө оруулалт юм.

Хууль зүй, Дотоод хэргийн яам болон Швейцарийн хөгжлийн агентлагийн 2019 онд хэрэгжүүлсэн “Иргэдийн оролцоо-2” төслийн Иргэний оролцоо гарын авлагад 2018 оны байдлаар Үндсэн хуулийн үзэл санаа, зорилго, зарчмын хүрээнд нийт 515 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 181 хуульд иргэдийн оролцоог хэсэгчлэн зохицуулсан 860 заалт байна гэжээ. Эндээс үзвэл хууль эрх зүйн хүрээнд төрийн бодлого, шийдвэр боловсруулах, хэрэгжүүлэх, хянах явцад иргэдийн оролцоо хангалттай хэмжээнд тусгаж өгсөн нь харагдаж байна. Гэвч бодит байдал дээр иргэдийн оролцоо хангалтгүй байгааг ОНХС-гийн үйл ажиллагаан дахь тэдний оролцооны байдлаас харж болно.

ОНХС нь орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг тухайн нутагт оршин суугаа иргэдээс гаргасан санал санаачилгын үндсэн дээр шийдвэрлэх, орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт дахь иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжихэд зориулан хуваарилж буй хөрөнгө оруулалт юм. Гэтэл сүүлийн үеийн судалгааны үр дүнгүүд нь энэ зорилго төдийлөн биелэхгүй буюу иргэдийн оролцоо сул байгааг харуулж байна. Тухайлбал, 2018 онд Дэлхийн банкны “Тогтвортой амьжиргаа-3” төслийн захиалгаар Удирдлагын академид “ОНХС-гийн цикл дэх иргэдийн оролцоо” судалгаа хийж, иргэдийн оролцоог сайжруулах зөвлөмж боловсруулсан байна. 2019 онд Конрад Аденауэр Сангийн дэмжлэгтэйгээр Төрийн байгуулалтын экспертийн зөвлөлийн судлаачдын багаас “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог бодловсронгуй болгох нь” сэдэвт бодлогын зөвлөмж боловсруулсан байна. Нөгөө талаас, олон улсын байгууллагын санхүүжилттэй иргэдийн оролцооны чиглэлээр олон тооны төсөл хөтөлбөр хэрэгжиж иргэд өөрсдийн оролцооны тухай ойлголт мэдлэг дээшилсэн байхуйц цаг хугацаа өнгөрчээ. Бодит байдал иргэдийн “оролцоо”-ны тухай ойлголт, мэдээлэл, мөн ОНХС-гийн тухай мэдээлэл тааруу байсаар байгаа нь харагдаж байна.

Орон нутгийн түвшинд нутгийн захиргааны удирдлага, нутгийн өөрөө удирдлагын хамтын ажиллагаа болон иргэд шийдвэр гаргахад оролцдог байх нь хөгжлийн үндэс нь юм. Энэхүү судалгааны ажил нь ОНХС-гаар тухайн орон нутагт хуваарилагдсан хөрөнгийг хамтдаа төлөвлөж, зарцуулж, хянаж чаддаг иргэдийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах асуудлыг

судалгаагаар тодорхойлж, оролцогч талуудыг мэдээллээр хангах ач холбогдолтой.

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Монгол улс 2013 оноос эхлэн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий “Орон нутгийн хөгжлийн сан”- г бий болгон 8 дахь жилдээ ажиллаж байна. Энэхүү сан нь Монгол улсын 21 аймгийн 329 сум, 1613 баг, нийслэлийн 9 дүүрэг, 173 хороонд нэгэн адил хэрэгжих үйл явц бөгөөд төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт-шинжилгээ үнэлгээ, хөрөнгийн удирдлага гэсэн 5 циклийг дамжин хэрэгждэг. Хэрэгжилтийн үр дүн нь аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хороо бүрт харилцан адилгүй байна. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэдтэй хамтран төлөвлөж хэрэгжүүлдэг бөгөөд энэ үйл явцад баг, хорооны Засаг даргаас эхлээд баг, хорооны Иргэдийн нийтийн хурал (цаашид ИНХ гэх) болон бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурал (цаашид ИТХ гэх) хүртэлх бүх шатны байгууллагууд оролцон хамтын шийдвэр гаргадаг.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан ОНХС-гийн журамд дурдсан санал авах 3 хэлбэрийн талаар иргэдэд мэдээлж, саналыг авах ажлыг зохион байгуулдаг. Ингэхдээ хорооны ИНХ-ын товын талаарх зарыг иргэдэд мөн хүргэнэ. Хорооны ИНХ дээр иргэдээс ирүүлсэн саналд суурилан бэлтгэсэн ирэх төсвийн жилд ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх урьдчилсан жагсаалтад багтсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал нэг бүрийг иргэдэд танилцуулж, саналыг нь хураана. Түүнчлэн иргэдийн хувьд Сангийн яамны ОНХС-гийн асуудал хариуцсан хэлтсээс хариуцаж ажиллуулдаг ОНХС-гийн удирдлагын мэдээллийн систем [1] -ээс энэ талаарх видео, аудио, хэвлэмэл баримт бичгүүдийг үзэх, өөрийн хороо, дүүргийн ОНХС-гийн эх үүсвэрээр санхүүжсэн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг авах боломжтой байхаар зохион байгуулалт хийсэн байна. Мөн төрийн санхүүгийн удирдлагын холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд иргэдийн оролцоот төлөвлөлт, оролцоот бодлого боловсруулалт, оролцоот төсөвлөлт, оролцоот аудит зэрэг ойлголтыг тусгаж хэрэгжүүлж байгаа [2].

Судлаач Кроуфорд Макферсон шударга, ил тод, хүмүүнлэг нийгэм илүү оролцооны улс төрийн системийг шаарддаг гэж үзээд орчин үеийн ардчиллын хөгжлийн сүүлийн үе шат нь оролцооны ардчилал хэмээн тодорхойлсон байдаг. Энэ хүрээнд төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүхий л үйл явц ил тод байж иргэд үүнд нийтээрээ хяналт тавин оролцох нь чухал гэж үзсэн. [3] Америкийн эрдэмтэн Ш.С.Арнштайн 1969 онд “Иргэдийн оролцооны шатлал” гэсэн загварыг боловсруулсан ба улс төр, төр захиргааны

байгууллагын зүгээс шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хөгжлийн 8 үе шаттай байна гэж үзсэн. [4]

Хүснэгт 1. Иргэдийн оролцооны хөгжлийн үе шат

| Оролцоо хангагдаагүй буюу оролцооны бус үе /2 шатлал/ | Оролцоог хэлбэрдэх үе /3 шатлал/ | Оролцооны идэвхтэй үе буюу оролцоо хангагдсан үе /3 шатлал/ |
|---|---|--|
| <ul style="list-style-type: none"> • Зохицуулалт хийх • Засах, сайжруулах | <ul style="list-style-type: none"> • Мэдээлэх • Зөвлөлдөх • Урамшуулах | <ul style="list-style-type: none"> • Хамтран ажиллах • Эрх мэдлээ шилжүүлэх • Иргэдийн хяналт |

Дээрх хүснэгтээс харвал төрийн байгууллага болон иргэд хамтран ажиллах, харилцан эрх мэдлээ шилжүүлэх, иргэдийн зүгээс хяналт тавьж чадвал бодит оролцоо буюу оролцоо хангагдсан гэж үздэг.

Иргэдийн оролцооны үе шат нь доороос дээш ахих тусам иргэдийн зүгээс нөлөөлөх нөлөөлөл нь улам бүр нэмэгддэг байна. Иргэдийн оролцоог хангах дараах хэлбэрүүд байдаг. Үүнд:

- **Мэдээлэл өгөх:** Иргэдэд бүрэн, бодитой бөгөөд тэнцвэртэй мэдээлэл өгөх
- **Зөвлөгөө авах:** Тухайн асуудлаар байгууллага, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авах, асуудалд дүн шинжилгээ хийн шийдвэр гаргах, шинэ санаа дэвшүүлэх
- **Татан оролцуулах:** Тухайн асуудалд иргэдийг татан оролцуулах замаар тэдний хүсэл эрмэлзлийг мэдэхээс гадна эргэлзээг тайлах
- **Хамтран ажиллах:** Улс төр, захиргааны зүгээс иргэдийг хамтран ажиллагч түлш хэмээн үзэж, шийдвэрийн төсөлд оновчтой хувилбаруудыг сонгон, хамтын шийдвэр гаргах зорилгоор хамтран ажиллах боломжийг эрж хайх
- **Иргэдээ эрхжүүлж, шийдвэр гаргах бүрэн эрхийг өгөх:** Бодлогын шийдвэрт иргэн удирдах, шийдвэрлэх эрхтэй оролцох зэрэг орно.

Ардчилсан нийгмийн иргэний хамгийн чухал эрхийн нэг нь оролцох эрх юм. Оролцооны хүрээнд иргэдийн хувийн санаачилга болон эрмэлзлийг дэмжихэд төрийн байгууллагын зүгээс үйл ажиллагаагаа чиглүүлдэг байх ёстой [5]. Өөрөөр хэлбэл ардчилсан нийгэм дэх сайн засаглалын шалгуур үзүүлэлт нь ил тод, хариуцлагатай, оролцоотой, үр ашигтай байх явдал бөгөөд төр засаг, харилцагч талууд ялангуяа идэвхтэй иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын оролцоотойгоор бий болдог [6]. Тэгэхээр сайн засаглал хөгжих үндэс суурь нь оролцоо хэмээн үзэж болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтөн дэх иргэдийн оролцооны өнөөгийн байдлыг тоон болон чанарын судалгааны аргыг ашиглан Хэнтий аймгийн жишээн дээр судалсан болно. Судалгааны явцад Хэнтий аймгийн ОНХС-гийн сүүлийн жилийн аудитын тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөөнд баримт бичгийн шинжилгээ хийсэн бол Хэрлэн сумын оршин суугчдаас санамсаргүй түүврийн аргаар санал асуулга авсан.

Судалгаанд сонгогдсон Хэнтий аймгийн Хэрлэн сум нь 6987 өрх, 23765 хүн амтай, аймгийн төв Чингис хот байрладаг, хүн ам ихтэй сумдын нэг юм. Судалгааны эх олонлогоос 7 хувийн алдааны магадлалтайгаар 190 өрхийг сонгож хамруулсан. Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийг нас, хүйсээр ангилж үзвэл хүйсний хувьд төлөөллийг жигд хангасан буюу нийт судалгаанд оролцогчдын 58.9 хувь нь эмэгтэй, 41.1 хувь нь эрэгтэй оролцогч байв. Энэ нь Монгол улсын хүн амын хүйсийн бүтцийн харьцаатай ойролцоо байгаа учир төлөөлөх чадвар сайн гэж үзлээ.

Судалгаанд оролцогчдын боловсролын байдлаар ангилж үзвэл дараах үр дүн гарч байна. Тухайлбал, 56.8 хувь нь дээд боловсролтой, 28.9 хувь нь мэргэжлийн боловсролтой, 14.2 хувь нь бүрэнд дунд боловсролтой иргэд хамрагдсан.

Судалгаанд оролцогчдыг ажил эрхлэлтийн байдлаар нь ангилж үзвэл төрийн байгууллагад оролцогчид хамгийн их хувь буюу 24.7 хувийг эзэлж байгаа ба ажилгүй иргэд хамгийн бага хувийг буюу 13.7 хувийг эзэлж байна. Ажил эрхлэлтийн байдлаар ангилсан үр дүнгээс харахад судалгаанд оролцогчид хөдөлмөр эрхлэлтийн ялгаатай бүлгүүдийг харьцангуй жигд төлөөлж чадсан байна.

Судалгаанд оролцсон иргэдийн орлогын хэмжээг мөн 5 шатлалаар авч ангилж үзсэн. Орлогоор нь ангилж үзэхэд хамгийн бага буюу сард 320 мянган төгрөг хүртэлх орлоготой иргэд нийт судалгаанд оролцогчдын 28.9 хувийг эзэлж байна. Судалгаанд оюутан болон ажилгүй иргэд, өндөр настны төлөөлөл бараг 40 орчим хувьтай оролцсон учраас бага орлоготой иргэдийн эзлэх хувь харьцангуй өндөр байв.

Хүснэгт 2. Та сум, багийн удирдлагуудаа таних уу?

| | Хэсгийн ахлагч | ИТХ-ын дарга | Багийн дарга |
|----------|----------------|--------------|--------------|
| Танихгүй | 69.5% | 74.2% | 48.9% |
| Танина | 30.5% | 25.8% | 51.1% |

Дээрх хүснэгтээс харвал хэсгийн ахлагч нараа танихгүй гэж 69.5 хувь нь, танина гэж 30.5 хувь нь, ИНХ-ын даргаа танихгүй гэж 74.2 хувь нь, танина гэж

25.8 хувь нь хариулсан. Мөн Багийн засаг даргаа танихгүй гэж 48.9 хувь нь танина гэж 51.1 хувь нь хариулсан байна.

Судалгаанд оролцогчдоос ИНХ-ын зар танд хэрхэн хүрдэг вэ? гэж асуухад:

- Гудамж, худаг, орц, дэлгүүр, хорооны самбарт байрлуулсан зараас-27,4%
- Хэсгийн ахлагчаас-15,3%
- Зарлал харж байгаагүй-49,5%
- Өөрөө асууж мэддэг-7,9%


Та ИНХ-д оролцож байсан уу? Хэрвээ оролцож байсан бол хэзээ оролцсон бэ?

- Оролцож байгаагүй-55,3%
- Оролцож байсан гэхдээ хэзээ оролцсоноо санахгүй байна-26,3%
- Хамгийн сүүлийн хуралд оролцсон-18,4%

Төрийн үйлчилгээний анхан шатны нэгжээс ямар үйлчилгээг хамгийн их авдаг талаарх судалгаанд оролцогчдын саналыг ихээс бага руу эрэмбэлбэл

- Оршин суугаа хаягийн тодорхойлолт авах
- Халамж, тэтгэмжтэй холбоотой асуудлаар хандах
- Цэргийн бүртгэл зэрэг албан ёсны бүртгэлд хамрагдах
- Өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах
- Сум, багийн хөгжил, тохижилтын асуудлаар мэдээлэл авах зэрэг үр дүн гарсан.

Зураг 1. Та сум, багийн Засаг даргадаа ямар нэгэн байдлаар хандаж, асуудлаа шийдвэрлүүлж байсан уу?



Та сум, багаас зохион байгуулж буй ямар нэгэн арга хэмжээнд оролцдог уу?

- Оролцох шаардлагагүй гэж үздэг-29.5%
- Зав гардаггүй-27.4%
- Яаж оролцохоо мэддэггүй-25,8%
- Оролцдог -17.4%

Сум, багийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоход танд юу шаардлагатай вэ?

- Мэдээ, мэдээлэл
- Сум, багийн ажилтнуудын харилцаа, хандлага
- Өөрийн хүсэл сонирхол
- Цаг зав
- Бусад зүйл


Хүнэгт 3. ОНХС-гийн талаарх иргэдийн ойлголт, оролцоо

| | Та ОНХС-гийн талаар мэдэх үү? | Өөрийн хорооны ОНХС-гийн төлөвлөлтөд оролцож байсан уу? |
|------|-------------------------------|---|
| Тийм | 63.2% | 53.7% |
| Үгүй | 36.8% | 46.3% |

Хүнэгт 4. ОНХС-гийн санхүүжилтээр хэрэгжсэн төслийн талаар та ямар мэдээлэлтэй байна вэ?

| | Гэрэлтүүлэг камержуулалт хийсэн | Засварын ажил хийсэн /Гудамж, байр, зам, барилгын засвар/ | Тохижилт хийсэн | Мэдэхгүй | Юу ч хийгээгүй |
|--------------|---------------------------------|---|-----------------|----------|----------------|
| Саналын хувь | 56.84% | 10.00% | 17.89% | 11.05% | 4.21% |

Зураг 2. ОНХС-гийн төлөвлөлтөд иргэдийн саналыг авч байгаа хэлбэр, хувиар



Судалгаанд Хэнтий аймгийн Хэрлэн сумын иргэдийн төлөөллийг хамруулж судалгааны үр дүнг чанарын судалгаагаар баталгаажуулахын тулд багийн Засаг даргатай ярилцлага хийж, ОНХС-гийн талаарх албан ёсны мэдээллийн хуудсууд болон орон нутгийн нийцлийн аудитын тайланд мөшгих судалгаа хийсэн. Багийн Засаг даргын ажлын албаны албан хаагчидтай хийсэн ярилцлагын үр дүн:

- Иргэдийн оролцооны идэвх сул байдаг иргэд гол төлөв шаардлагатай тохиолдолд л сум багаас зохион байгуулж байгаа ажилд оролцдог. Халамж шаардлагатай иргэд л сум багт асуудал тавьж ханддаг.

- Багийн Засаг дарга ажлын ачааллаас шалтгаалж айл өрхөд мэдээлэл түгээж, ОНХС-гийн төлөвлөлтөд иргэдийг оролцуулж санал авах хуудсыг бүрэн бөглүүлж авах боломж хязгаарлагдмал байдаг. Амьдралын боломжтой, дундаж насны иргэд айл өрх тэр бүр нийтэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд оролцох эрмэлзэл бага байдаг.
- Гэр хорооллын оршин суугч иргэддээ зар түгээх болон судалгаа мэдээлэл авахад иргэдийн бүлгүүдийн үйл ажиллагаа идэвх чухал нөлөөлдөг гэдгийг дурдсан.

Сошиал орчинд ОНХС-тай холбоотой албан ёсны мэдээллийн хуудсуудын мэдээлэл, иргэдийн санал сэтгэгдлийн ажиглалтын үр дүн:

- Технологийн дэвшилтэт хэлбэр нь олон давуу талтайн зэрэгцээ 1 хүн олон удаагийн хандалтаар санал өгөх, тухайн орон нутгийн харьяалалгүй иргэн санал өгөх гэх мэт сөрөг талуудыг өөртөө агуулж байдаг. Иймд цахим хэлбэрээр санал авах тохиолдолд санал өгөгчийн суурь мэдээллийг /овог, нэр, хаягийн бүртгэл, нас гэх мэт/ заавал авдаг байх, нэг төхөөрөмжөөс өгөх саналын тоонд тодорхой хязгаар байх зэргийг зохицуулах нь чухал юм.
- “Орон Нутгийн Хөгжлийн Сан” фэйсбүүк хуудас 2018 оны 05 дугаар сарын 21-нд үүсч өнөөдрийг хүртэл 2,175 дагагчтай болсон байна. Пэйж хуудсанд цаг үеийн холбоотой мэдээлэл болон ОНХС-тай холбоотой дүрэм журмууд, түүний хэрэгжилтийг дүрсжүүлж бичлэг болгон маш сонирхолтой байдлаар зурагт хуудсуудыг нийтэлсэн нь иргэдэд хүргэх мэдээлэл “сонирхолтой, энгийн” байх зарчимд уул нь нийцэж байна.
- Монгол Улсын Сангийн Яамны албан ёсны фэйсбүүк хуудас 2018 оны 02 дугаар сарын 23-нд үүсч нийт 5,384 дагагчтай болсон байна. Пэйж хуудсанд улсын төсөв, орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн тухай цаг үеийн мэдээлэл шуурхай тавигддаг.
- Мөн иргэний оролцооны чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаа төсөл хөтөлбөрүүдийн албан ёсны хуудсуудад дагагчийн тоо энтертайнмент, үйлчилгээ, худалдааны чиглэл, сонирхлын бүлэгт тулгуурласан фэйсбүүк хуудасны дагагчийн тооноос хэд дахин цөөн байгаа нь ажиглагдлаа.

Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын 2019 онд дүгнэсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт нийцлийн аудитын тайланд хийсэн судалгааны үр дүн [7]:

- Хэнтий аймгийн хэмжээнд 2018 онд 236 хөтөлбөр, төсөл арга хэмжээг ОНХС-гаас нийт 3713.9 сая төгрөгөөр санхүүжүүлсэн ба орон нутгийн

өмчид 1906.3 сая төгрөг, төрийн өмчид 81.0 сая төгрөг, төрийн бус байгууллагад 250.7 сая төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байна. Аймаг, сумын ИТХ-ийн дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд давхардсан тоогоор нийт 166 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, сумын ЗДТГ-ууд 36 хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл явцад хяналт шинэжилгээ хийж мэдээллийг тайлагнажээ.

- Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн сангийн цахим мэдээллийн санд нийт 217 арга хэмжээний төсөвт өртөг, худалдан авах ажиллагаа, санхүүжилт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг байршуулсан байна.
- Нийцлийн аудитын тайланд дурдсанаар үндсэн хэдэн зөвлөмж, дүгнэлт аймгийн удирдлагад хүргүүлсэн нь сум, багийн түвшинд иргэдийн оролцооны хяналт сул, хамтран ажиллах зохион байгуулалт тааруу байгааг харуулж байна.

Хэнтий аймгийн Хэрлэн сум нь өмнөх онуудын ОНХС-гийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог ОНХС-гийн журамд заасан иргэдээс санал асуулгын хуудсаар санал авах байдлаар зохион байгуулсан бол 2020 оны ОНХС-гийн төлөвлөлтөд цахим хэлбэрээр санал авсан. Гэвч иргэдийн оролцооны ирц 34,5%-тай байгаа тухай багийн ажилтан, албан хаагчид хэлж байсан.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ОНХС-гийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд санал болгох дараах хувилбарыг дэвшүүлж байна. Үүнд:

1. *Бэлтгэл ажлыг хангах.* Энэ үе шатанд ОНХС-гийн төлөвлөлтөд иргэдийг хэрхэн оролцуулах, иргэдэд ямар мэдээллийг хүргэх, мэдээлэл нь ямар хэлбэр, загвартай байх, мэдээллийг ямар сувгаар хүргэх зэрэг ажлыг нарийн төлөвлөж бэлтгэх хэрэгтэй. Ялангуяа иргэдийг мэдээллээр хангах ажлыг эртнээс хийж эхлэх нь үр дүнтэй бөгөөд энэ нь эргээд иргэдийн оролцох идэвхийг нэмэгдүүлнэ.
2. *Иргэдийн саналыг авах.* Энд иргэдийг мэдээллээр хангасны дараа тэдний саналыг авах ажлыг хэрхэн зохион байгуулахаа төлөвлөнө. Тухайлбал орон нутгийн иргэдийн онцлогт тохируулан санал авах арга хэлбэр (санал асуулгын хуудас бөглүүлэх, бүлгийн ярилцлага хийх, цахим хэлбэрээр санал авах)-ээ тодорхойлох, ирсэн саналуудыг нэгтгэх, төслийн саналын урьдчилсан жагсаалтыг бэлтгэх үйл ажиллагааг энэ шатанд хийж гүйцэтгэнэ. Мөн багийн Засаг дарга хамтран ажиллах хүмүүсээ тодорхойлох, тэднийг нэгдсэн зохион

байгуулалтад оруулах иргэдийн дунд хэлэлцүүлгийг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зэрэг ажлуудыг төлөвлөх нь чухал юм.

3. *Багийн иргэдийн нийтийн хурлаар төслийг батлах.* Энэ үе шатанд ИНХ-ыг хүчин төгөлдөр ирцтэйгээр зохион байгуулах, иргэдээс ирсэн саналын танилцуулга болон нэмэлт төслийн саналыг хүлээн авч, төслүүдийг иргэдийн оролцоотойгоор эрэмбэлсэн төслийн жагсаалтыг бэлтгэх зэрэг ажлуудыг хэрхэн хийхээ төлөвлөнө. ОНХС-гийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангахад орон нутгийн удирдлага, түүний хамтран ажиллах хүмүүсийн мэдлэг чадвар, идэвх санаачилга хамгийн чухал бөгөөд энэ нь иргэдийн саналыг бодитой авч, түүнийг эрэмбэлэх үйл ажиллагааг хэрхэн зөв чиглүүлж чадахаас ихээхэн хамаарна.
4. *Эргэх холбоотой ажиллах.* Энд багийн ИНХ-аас гаргасан тогтоолыг бэлтгэсэн төслийн жагсаалт, тодорхойлолтын хамтаар сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ. Мөн багийн ИНХ болон сумын ЗДТГ-аас ямар шийдвэр, үр дүн гарсныг иргэдэд эргэж мэдээлэх ажил хийгдэнэ. Иймээс иргэдэд мэдээллийг хэзээ, хэрхэн түгээх ажлыг урьдчилан төлөвлөж төлөвлөгөөнд тусгах хэрэгтэй.

ДҮГНЭЛТ

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцооны өнөөгийн байдлыг Хэнтий аймгийн жишээн дээр судалсны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Иргэдийн оролцооны хамгийн эхний алхам болох иргэд сум, багтаа хандаж тулгамдсан асуудлаа шийдвэрлэж байсан эсэхийг тодруулахад иргэдийн төрийн удирдлагын хамгийн анхан шат болох хорооны үйл ажиллагаанд анхаарал хандуулах, сум, баг, хороондоо асуудал тавьж шийдвэрлүүлэх байдал төдийлөн хангалттай биш буюу идэвхгүй түвшинд байна. Сумаас иргэд зөвхөн шаардлагатай тохиолдолд хандаж тодорхойлолт гаргуулах, халамжийг үйлчилгээ авах төдийгөөр оролцоо хязгаарлагдаж байна.
- Багаас зохион байгуулж буй аливаа үйл ажиллагаанд иргэд оролцохгүй байх, ОНХС-гийн төлөвлөлтөд оролцож байгаа хэлбэр нь хангалттай бус байна. Иргэдийн 63,2% нь ОНХС-гийн тухай мэднэ гэсэн боловч 53,7% нь өөрийн хорооны ОНХС-гийн үйл явцад оролцож байгаагүй гэж хариулсан судалгааны үр дүн илэрхийлж байна. Энэ нь мэдээлэл дутмаг байдалтай хамааралтай байх талтай. Иргэд ОНХС-гийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцохын тулд тэдэнд чиглэсэн мэдээллийг ойлгомжтой, хүртгээмжтэй, ил тод, оновчтой хэлбэрээр хүргэх хэрэгтэй

гэж үзсэн. Түүнчлэн сум, баг, хорооны албан хаагчдын харилцаа, хандлага, асуудал зохицуулах чадвар зэрэг байдал нь иргэдийг үйл ажиллагаандаа татан оролцуулах бас нэгэн арга зам болох нь судалгаанаас харагдаж байна.

- Иргэдийн Нийтийн Хурал иргэдийг идэвхжүүлэх тал дээр анхаарч Засаг даргын ажлын албатай хамтран ажиллах шаардлагатай байгаа нь судалгаанд оролцогчдын 54.7% нь хороондоо 6 ба түүнээс дээш жил оршин суусан боловч ИНХ-даа 55 % нь оролцож байгаагүй, 49.5% нь ИНХ-ын зарлал харж байгаагүй гэсэн судалгааны үр дүнгээр нотлогдож байна. ИНХ-ыг ирц сайтай амжилттай зохион байгуулахад, иргэдийг тулгамдаж байгаа асуудал, сонирхлын бүлгээр хувааж хэлэлцүүлэг өрнүүлвэл үр дүн сайтай байж болох талтай.
- Иргэд ОНХС-гийн төлөвлөлтөд саналаа өгснөөр санал нь цаашид бодит ажил болно хэмээн ойлгодог боловч, эргээд санал нь дэмжигдээгүй тохиолдолд ОНХС-гийн үйл ажиллагаанд хандах хандлагад сөргөөр нөлөөлж улмаар иргэдийн оролцоог бууруулах хүчин зүйл болж байна. Иймд иргэдэд эрэмбэ дараатай жил тутам тулгамдаж буй асуудлаа шийдвэрлээд явах байдлаар хамтарч ажиллах нь үр дүнтэй гэдгийг сайн ойлгуулж, мэдээлэх нь чухал юм.
- Судалгааны үр дүнгээс төрийн үйлчилгээг иргэдэд хамгийн анхдагч байдлаар хүргэж ажилладаг баг, хорооны хэсгийн ахлагчийн ажлын байрны нөхцлийг сайжруулах, нэг ахлагчид ногдох өрхийн тоог бууруулах нь иргэдийн оролцоог хангах ажлын бас нэгэн суурь болж өгнө гэж үзэж байна.
- Багийн ИНХ-аар иргэдээс санал авч эрэмбэлэх нь хамгийн чухал үйл ажиллагаа учраас цаг хугацаа, орон зайн хувд алслагдмал байгаа оршин суугчдаас бүлгийн аргаар санал авах нь бас үр дүнтэй байж болох юм. Жишээ нь зохион байгуулалттай бүлгийн хувьд 50-иас дээшгүй иргэн, алслагдсан багийн хувьд 30-аас доошгүй иргэний бүрэлдэхүүнтэй байх ба бүлгийн ярилцлага хэлэлцүүлгийг жилд хоёроос доошгүй удаа хийсэн байна. Мөн хот айл, ойролцоо нутагладаг иргэд тус бүр сонирхлын бүлгээрээ нэгдэж, ОНХС-гийн төслийн саналаа хэлэлцэж, тэмдэглэл хөтлөн, өөрсдийн төлөөллөө сонгон багийн ИНХ-д илгээж болно.
- Түүнчлэн Ерөнхий Боловсролын Сургуулийн сургалтын хөтөлбөрт нийгмийн ухааны хичээлийн тусгай сэдэв болгож оруулж өгөх нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

[1] www.tusuv-oronnutag.mof.gov.mn

[2] Түмэнцогтоо Т, Бямбасүрэн Я болон бусад. *Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслүүд*. УБ., 2017, х 16

[3] Улс төрийн шинжлэх ухааны нэвтэрхий толь бичиг. УБ., 2020, х 417

[4] КАС, МУИС. *Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь*. УБ., 2019, х 202

[5] ШУТИС. *Төрийн удирдлага*. УБ., 2019, х 154

[6] КАС, МУИС. *Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох нь*. УБ., 2019, х 197

[7] Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газар 2019, “Орон нутгийн хөгжлийн сангийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт” нийцлийн аудитын тайлан